

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮН

ТОВХИМОЛ

3

СУМ, БАГ, ХОРООНЫ НИЙГМИЙН
АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА



Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Зохиосон: А. Батхишиг, PhD
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
I дүгээр хороо, Аризона төв, 4-р давхар

Шуудангийн хайрцаг:
Төв шуудан, ш/х-1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976-11-329365,
+976-11-329371

Факс: (976-11) 329361

И-Мейл: secretary@savethechildren.mn

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: www.savethechildren.mn

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮН СУМ, БАГ, ХОРООНЫ НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА

НИЙГМИЙН АЖИЛТАН БА ХАМТАРСАН БАГ

Нийгмийн ажилтны олон улсын холбоо 2014 онд "Нийгмийн ажил нь нийгмийн өөрчлөлт, нийгмийн хөгжил, хүмүүсийн нэгдмэл байдал, чадваржуулалтыг хөхиүлэн дэмждэг практик үйл ажиллагаанд суурилсан мэргэжил бөгөөд шинжлэх ухааны салбар мөн" гэж тодорхойлсон. Энэ нь олон улсын нийгмийн ажилтнууд өнгөрсөн зуу гаруй жилийн мэргэжлийн хөгжлийн түүх, мэдлэг, туршлага дээрээ үндэслэн нийгмийн ажлыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжил бөгөөд шинжлэх ухааны салбар гэдгийг дэлхий дахинаа дахин тунхагласан. Монгол Улсын хувьд нийгмийн ажил нь мэргэжил гэдэг утгаараа 1996 оноос эхлэн хурдацтай хөгжиж байгаа мэргэжлүүдийн нэг. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд Монгол Улсын хэд хэдэн хуульд нийгмийн ажлын үйлчилгээ, мэргэжлийн нийгмийн ажилтны үүргийн тухай хуулчлан зааж, нийгмийн хамгаалал, халамж, боловсрол, эрүүл мэнд, засан хүмүүжүүлэх, нийгмийн хөгжил, хүний эрх зэрэг нийгмийн олон чухал салбарт хэдэн зуун мэргэжлийн нийгмийн ажилтнууд ажиллах болсон. Нөгөө талаас Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын хуулинд нийгмийн ажилтан нь хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл дарамтаас хамгаалахад оролцож, тэдний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй гэж заасан. 2016 оны 2 сард батлагдсан Хүүхэд хамгааллын тухай анхны хуульд нийгмийн ажилтан нь хүүхэд хамгааллын чиглэлээр ялангуяа эрсдэлт нөхцөл байдал байгаа хүүхдийг судлан тогтоох, хүчирхийлэл ба дарамтад өртсөн хүүхдийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах талаар шуурхай арга хэмжээг шат дараалан авах тухай тусгайлан дурдсан (Хавсралт 1: Хүүхэд хамгааллын хуулийн 19 дүгээр зүйл).

Энэ гарын авлагын 2-оос 4 дүгээр хавсралтуудад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Халамжийн тухай хуулиудад нийгмийн ажилтнууд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүлээсэн үүрэг бүхий заалтуудыг тусгасан. Нийгмийн ажилтан нь хүчирхийлэл, дарамтад өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхэд, эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалал ба халамжийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй тухай тусгасан. Энэ утгаараа хамтарсан багийн нийгмийн ажилтан нь нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ үзүүлэх хуулиар олгогдсон эрх бүхий цөөн мэргэжилтнүүдийн нэг болдог.

Монгол Улсын хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх салбарт гарсан нэг ололт бол нийгмийн ажилтан бусад салбарын мэргэжилтнүүдтэй хамтран багаар ажиллах санаачлага гарч, энэ санаачлагыг хууль эрх зүй болон нийгмийн үйлчилгээний хүрээнд хүлээн зөвшөөрсөн явдал юм. Хамтарсан багаар ажиллах нь хүүхэдтэй зүй бус харьцах явдалтай тэмцэхэд салбар дундын мэргэжилтнүүдийг оролцуулан, хүүхэд хамгааллын асуудлыг илүү өргөн хүрээтэй хэлэлцэж, нөхцөл байдлын үнэлгээг нарийвчлан хийх, нийгмийн үйлчилгээг чанартай хүргэх, байгууллагуудын болон мэргэжилтнүүдийн уялдаа холбоог хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Гэсэн хэдий ч шинэ тулгар хөгжиж буй "хамтарсан багийн үйл ажиллагаа нь өнөөгийн байдлаар орон нутгийн түвшинд нутгийн өөрийн удирдлагын болон захиргааны шийдвэрээр байгуулагдаж, эргээд тэдгээр байгууллагын өмнө ажлаа тайлагнах жишгээр явж байна"¹.

¹ Г.Түмэннаст, Т.Бүрэнжаргал, Н.Болдмаа, бусад (2015). Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа, УБ, ХИС.

Хамтарсан багийн өнөөгийн байдлын тухай (2015) судалгаагаар хамтарсан багийн талаарх олон нийтийн ойлголт хангалтгүй, судалгаанд оролцсон нийт хүүхдийн 70%, эцэг эх, насанд хүрэгчдийн 80% нь хамтарсан багийн талаарх мэдээлэл байхгүй байна гэсэн дүн гарчээ.

Мөн хамтарсан баг тухайн орон нутагтаа хүүхэд хамгааллын үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрт хүрч чадалгүйгээр, онцгой ямар нэгэн асуудал бий болсны дараагаар л ажилладаг практик тогтож байгаа тухай судлаачид тэмдэглэсэн². Түүнчлэн хамтарсан багийн гишүүд нөхцөл байдлын үнэлгээг нэгдсэн буюу тогтсон маягтын дагуу хийдэггүй, тэдний хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, бусад байгууллагын үйлчилгээтэй холбон зуучлах мэдлэг чадварыг нэмэгдүүлэх шаардлага байгаа тухай энэ судалгаанд дурджээ.

Энэ бүхнээс харахад хамтарсан багийн гишүүд, тэр дундаа ажил үүргийнхээ хүрээнд хамтарсан багийн гишүүдтэй хамгийн ойр ажилладаг нийгмийн ажилтны хувьд хамтарсан багийг үр дүнтэй ажиллуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд онцгой анхаарах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Олон мэргэжилтнүүдээс бүрдсэн хамтарсан багийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хамтын ажиллагааг хөгжүүлэхэд нийгмийн ажилтан чухал үүрэгтэй. Нийгмийн ажилтан нь хамтарсан багийн хамтын хүчин чармайлтанд тулгарч буй саад бэрхшээлийг соргоогоор ажиглаж багийн ахлагч болон бусад мэргэжилтнүүдийн тусламжтайгаар тэр саад бэрхшээлийг даван туулахад гар бие оролцоно.

Нийгмийн ажилтан бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахад тулгарах бэрхшээлийг хэрхэн даван туулах тухай дараах зөвлөгөө³г өгсөн байдаг. Үүнд:

1. Хамтарсан багийн гишүүдийн итгэлцлийг бий болгох. Харилцан итгэлцэлгүйгээр гишүүд өөрсдийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын санаа бодлыг сонсох, хуваалцахад хүндрэл гарна. Иймээс нийгмийн ажилтны зүгээс багийн гишүүдийн дунд харилцан илтгэлцлийг бий болгохын тулд хамтарсан багийн дүрэм, журмыг хэлэлцэж, бие биенээ хүндэтгэх, хэлэлцэж буй кейсийн талаарх мэдээллийн нууцыг чанд хадгалах талаар харилцан тохиролцож, хамтран ажиллах хэм хэмжээгээ тогтоох нь чухал гэж үздэг.
2. Багийн гишүүдийн дунд ажил төрлийн маргаан ба өрсөлдөөн үүсэхэд багийн гишүүдийн үүрэг, даалгаврыг тодорхой болгох, хамтран ажиллах давуу ба сул талуудын талаар гишүүдийн ажиглалт дүгнэлтийг хэлэлцэх боломжийг гаргах, ажил хэрэгч илэн далангүй ярилцлага өрнүүлэх нь нэн тустай. Хүчирхийлэл дарамтад өртсөн хүүхэд, гэр бүлийн аюулгүй байдлыг хангах, тэдэнд олон талт үйлчилгээ үзүүлэхэд багийн гишүүд ямар үүрэг гүйцэтгэх, улмаар тэд юу хийж чадах талаар үйлчилгээний төлөвлөгөө гаргах үед нийгмийн ажилтан бусад гишүүдээ оролцуулахад, тэдний санаа бодлыг тусгахад онцгойлон анхаарна.
3. Багийн гишүүдийн хариуцлагын асуудал нь хамтын ажиллагаанд чухал нөлөөтэй. Үйлчлүүлэгчийн кейсийг хариуцаж буй кейс менежерийн хувьд нийгмийн ажилтан нь багийн гишүүдэд цаг хугацаандаа хүлээсэн үүрэг даалгавраа биелүүлэх талаар сануулж, төлөвлөсөн ажлын явцыг бүх гишүүдэд мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд бусад зохицуулалтын арга хэмжээг авах хэрэгтэй болно.

² Дээрх судалгаа, хуудас (141 – 143)

³ Воодсайд, Маклам, Вильсон (2003). Нийгмийн ажлын кейс менежмент ба үйл явцын тэмдэглэл, хуудас 165–167. УБ: Копир Тех, ХХК

4. Хамтарсан багийн гишүүдийн харилцааны хэм хэмжээг тогтооход нийгмийн ажилтан чухал үүрэг гүйцэтгэнэ. Нийгмийн ажилтан өөрөө үлгэр дуурайл үзүүлэн, ойлгомжтой ил тод харилцаж, бусдыг сонсон, гишүүдийн санал багийн шийдвэрт тусгагдсан эсэхэд санаа тавих тавих хэрэгтэй болно.

Түүнээс гадна нийгмийн ажилтан мэргэжил нэгт нөхөд болон хамтран ажилладаг багийн гишүүдтэй зэрэг, ажил хэрэгч харилцаа холбоог бий болгох явдал их чухал. Триуттийн санал болгосон ажил хэргийн харилцааг амжилттай болгох дараах зөвлөмж анхаарч ажиллахад тустай⁴.

Тэрээр ажил хэргийн харилцааг амжилттай болгоход: (1) нөхөрсөг байх, уулзалтыг нээх ба удирдахдаа хамтач байр сууринаас хандах; (2) энгийн байхын зэрэгцээ бодлого, чиглэлээ цэгцтэй ойлгомжтой тайлбарлах, хэлэлцүүлгийн дүн хүн бүрт тодорхой байх; (3) хамтарсан багийн хурлын шийдвэр, шалтгааны талаар гишүүн бүр мэдэж, бусдад тайлбарлаж чаддаг байх; (4) багийн гишүүдийн хийх ажил, авах арга хэмжээ тодорхой байх, асуудлыг хэлэлцэхэд гишүүд идэвхтэй оролцон, хийх ажлаа хамтран тодорхойлох; (5) багийн гишүүдтэй эргэх холбоотой байх, үйлчлүүлэгчид гарч буй өөрчлөлтийг баримт нотолгоогоор баяжуулж, өөрчлөлтийн талаарх мэдээллийг багийн гишүүдэд танилцуулах гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байдаг.

Нийгмийн ажилтан нь хамтарсан багийн үйл ажиллагааг үр дүнтэй болгох эдгээр санал зөвлөмжүүдийг нийгмийн ажлын үйлчилгээний бүх үе шатуудад анхааран, хамтарсан багийн гишүүдийн оролцоог дэмжин ажилласнаар хүүхэд хамгааллын чиглэлээр хамтарсан багийн үйл ажиллагааг шинэ шатанд гарахад чухал хувь нэмэр оруулах болно. Нийгмийн ажлын үйлчилгээний шат тус бүрт тухайлбал нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, үйлчилгээг үнэлэх ба хаах үе шатуудад нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдтэй болон дангаараа ажиллах талаар дэлгэрэнгүй өгүүлье.



⁴ Воодсайд, Маклам, Вильсон (2003) нарын дээрх ном, хуудас 167–168.

I. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Нийгмийн ажилтан нь аливаа мэдээллийг хүлээн авч, үйлчилгээг үзүүлэхийн өмнө нөхцөл байдлын үнэлгээг зайлшгүй хийнэ. Үйлчлүүлэгчид тулгарч буй асуудлаас хамаарч нөхцөл байдлын үнэлгээг хэд хэдэн хэлбэрээр хийнэ. Үүнд: эрсдлийн ба аюулгүй байдлын үнэлгээ, хэрэгцээний үнэлгээ, эрхийн зөрчлийн үнэлгээ гэх мэт үнэлгээний хэлбэрүүд байдаг.

Хүүхэд хамгаалал болон гэр бүлийн хүчирхийллийн тохиолдолд хүүхэд, эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, тэдэнд тулгарч болох эрсдэл, аюулгүй байдлыг тодорхойлох үнэлгээнд голлон анхаардаг бол, ядуурал, ажилгүйдэл, сургууль завсардал гэх мэт асуудал тулгарахад хэрэгцээний үнэлгээ, эрхийн зөрчлийн үнэлгээ гэх мэт үйлчлүүлэгчид тулгарч буй асуудал, эрхийн зөрчлийг илрүүлэхэд чиглэсэн нөхцөл байдлын үнэлгээг хийнэ. Эрсдлийн үнэлгээ ба хэрэгцээний үнэлгээг хамтад нь хийж болох бөгөөд энэ хэлбэрийн нөхцөл байдлын үнэлгээг дуул буюу хоёр чиглэлийн үнэлгээг зэрэг хийх⁵ хосолсон үнэлгээ гэж нэрлэдэг. Хосолсон үнэлгээ нь үйлчлүүлэгчид тулгарах аюулын эрсдлийг үнэлэх явцдаа үйлчлүүлэгчийн хэрэгцээ, тулгарч буй бусад асуудлын тухай мэдээллийг нөхцөл байдлын үнэлгээндээ бас багтаана гэсэн үг.

Хосолсон нөхцөл байдлын үнэлгээний загварыг ХТҮГ-ын 2016 оны 4 сарын 16-ны өдөр батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт”-ын гэр бүлийн нөхцөл байдал, хэрэгцээний үнэлгээнээс харна уу.

Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол мэдээлэгдэх, илрэхэд хүүхэд болон хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангах ажил нь хамтарсан багийн нэн тэргүүнд хийх ажил болдог. Иймд эрсдлийн үнэлгээний үе шатуудын талаар тусгайлан дурдъя.

Хүүхэдтэй зүй бусаар харьцсан тухай мэдээлэл авсан, эсвэл хүүхэдтэй зүй бусаар харьцсан шинж тэмдэг хүүхдэд илрэх тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг дараах дарааллаар хийнэ. Үүнд:

1. Хүүхэдтэй зүй бусаар харьцсан эсэх, хүүхэд ямар хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөнийг тодорхойлно. Үүнд хүүхдийг үл хайхарсан эсэх, хүүхэд бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэх, бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэх, сэтгэл санааны дарамтад өртсөн эсэхийг тус тус тогтооно.
2. Хүүхдийн аюулгүй байдал хэр хангагдсан, хэрэв хүчирхийлэл, дарамтад өртөх аюултай нөхцөлд байгаа бол ямар түвшинд байгаа, ямар ямар эрсдлийн хүчин зүйлс нөлөөлж байгааг эрсдлийн үнэлгээгээр тодорхойлно. Хүүхэд хамгааллын үйлчилгээний маягтаас эрсдлийн үнэлгээний маягтыг (хуудас 10) харна уу. Энэ үед шатанд аюулгүй байдал ба эрсдлийн хүчин зүйлсийг тус тусад нь үнэлнэ. Аюулгүй байдлыг үнэлнэ гэдэг нь хянах ёстой ямар аюул занал байгааг тогтоодог бол эрсдлийн үнэлгээ нь аюулгүй байдалд хүргэж болох, аюулын зэргийг нэмэх хүчин зүйлс байгаа эсэхийг олж тогтоон, засаж залруулах боломжийг судална. Өөрөөр хэлбэл аюулгүй байдал нь одоо яг ямар аюул занал хүүхэд, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл



⁵ А. Батхишиг (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ номны гуравдугаар бүлэг. Нөхцөл байдлын үнэлгээ. хуудас 95. ХИС. УБ: Хөх судар принтинг.

мэндэд тулгарч байгааг тогтоож цаг алдалгүй шуурхай авах арга хэмжээг тогтоодог бол эрсдлийн үнэлгээ нь ямар эрсдэл, аюул занал тулгарч болохыг урьдчилан харж, болзошгүй аюул заналаас хүүхэд, гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээг тодорхойлоход тустай.

Аюулгүй байдлын үнэлгээ нь «Хүүхдэд одоо яг юу хэрэгтэй байна вэ» гэсэн асуултанд хариулахыг зорино. Аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд тулгарч буй аюул заналыг таслан зогсоох, хүүхдийг аюулгүй байдалд шилжүүлэхтэй холбоотой яаралтай буюу шуурхай тусламжийн арга хэмжээ юм (А. Батхишиг, 2008, 2009)

Эрсдлийн хүчин зүйлсийн үнэлгээ нь тулгарч болох бүх эрсдлийн хүчин зүйлсийг хамрах ба тэдгээр эрсдэл нь нийлж, даамжирч аюултай нөхцөл байдал үүсч болох эсэхийг анхаарна. Эрсдлийн хүчин зүйлийн тоо хэмжээ, ноцтой байдал үүсэх нөхцөл, нөлөө үзүүлэх хугацаа ялангуяа хохирогч хүүхэд ба асран хамгаалагчийн эрүүл мэнд ба хүчирхийлэл үйлдэгчээс хараат байдал, хүүхдийн гэр бүлийн бусад гишүүд эрсдлийг хянах боломж, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах хүүхэд, гэр бүл ба орчны давуу ба сул талууд, тухайн эрсдэлд чиглэсэн үйлчилгээ авах боломж хир байгаа зэрэг эрсдлийн үнэлгээнд багтаана (А. Батхишиг, 2008, 2009).

3. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн төлөвлөгөөг боловсруулна. Аюулгүй төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа нь хүүхдэд аюул занал учруулах эрсдлийн хүчин зүйлсийг хянах зорилготой. Тиймээс аюулгүйн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа, үйлчилгээ нь эрсдлийн хүчин зүйлст нэн даруй нөлөө үзүүлэхүйц, аюул занал учруулах өндөр эрсдэлтэй үед хүүхэд ба түүний гэр бүлийн гишүүд шуурхай тусламж үйлчилгээ авахад бэлэн, боломжтой эсэх, эцэг эх асран хамгаалагчийн зүгээс хүүхдийг хамгаалах боломжтой эсэх, бусад хамгаалах хүчин зүйлсийг хэрхэн бэхжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа зэргийг тус тус багтаана.
4. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал үүссэн үед хүүхэд, түүний гэр бүлд ямар тусламж, дэмжлэгийг шуурхай үзүүлэх шаардлагатайг тодорхойлно. Яаралтай шуурхай тусламжийн үйлчилгээнд эмнэлгийн тусламжтай холбох, аюул заналыг таслан зогсоох, хоол хүнс, хувцас, орон байраар хангах, холбогдох үйлчилгээтэй холбох, хямралын эсрэг үйлчилгээ үзүүлэх бусад үйлчилгээтэй холбох зэрэг үйлчилгээ багтана.
5. Хүүхдэд учрах аюул бага, эрсдлийн түвшин бага гэж үзсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн хэрэгцээг үнэлэх, эрхийн зөрчлийг шийдвэрлэхэд чиглэсэн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулна.

Хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу нийгмийн ажилтан эрсдлийн үнэлгээ болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг цаг алдалгүй шуурхай хийх ажлыг гардан зохион байгуулна. Хамтарсан багийн бусад гишүүдийн хувьд өөрсдийн ажил мэргэжил, хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу нөхцөл байдлын үнэлгээнд оролцоно. Жишээ нь эмч болон эмнэлгийн мэргэжилтнүүд нь хүүхэд ямар хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн, хүүхдийн эрүүл мэнд амь насанд ямар аюул занал учирсан ба учирч болох ямар ямар эрсдэл байгааг тодорхойлох, бусад нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн

байгууллагатай холбоход гол үүрэг гүйцэтгэнэ. Цагдаа болон хүчний байгууллагын ажилтнууд нь хүүхэд, гэр бүлийн аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээ үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх, сургах, хянах зэрэг үйл ажиллагаанд тэргүүлэх үүрэгтэй оролцоно.

Нийгмийн ажилтны хувьд хамтарсан багийн гишүүдтэй цуг нөхцөл байдлын үнэлгээ хийх явцад гишүүдийн ажил үүрэг, тэдний байгууллагын зорилго, чиглэл, үнэт зүйлс, улмаар бусад мэргэжилтнүүдийн үнэлгээ, оношлох арга техник, хэрэглэдэг нэр томъёо зэрэг нь ялгаатай байдаг⁶ гэдэгт анхаарах ёстой. Эдгээр ялгаатай арга техник, нэр томъёоны талаар багийн бусад гишүүдтэйгээ зөвшилцөн ойлголцоход анхаарал хандуулна. Нөхцөл байдлын үнэлгээнд хамтарсан багийн гишүүдийг татан оролцуулснаар тухайн үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын талаарх олон талт мэдээллийг цуглуулах, үйлчлүүлэгч болоод гэр бүлийн асуудлыг шийдэх боломжийг илүү өргөн хүрээнд харах боломжтой болно.



⁶ Воодсайд, Маклам, Вильсон, (2003). Нийгмийн ажлын кейс менежмент ба үйл явцын тэмдэглэл, хуудас 171

II. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛӨВЛӨХ

Эрдэмтэн Жонсоны тодорхойлсноор нийгмийн ажлын үйлчилгээ нь харилцаа холбоог тогтоон барих, тодорхой нэг зан үйлийг өөрчлөх, харилцаа холбоог өөрчлөх, үйлчлүүлэгчийн орчинг өөрчлөх, чиглэл өөрчлөх гэсэн таван чиглэлээр өөрчлөлт гаргахыг зорьдог⁷. Тиймээс нийгмийн ажлын үйлчилгээ, ялангуяа хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээ нь эдгээр таван чиглэлийн өөрчлөлтөд чиглэдэг. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьд хүүхэдтэй зүй бус харьцах явдал нь ямар түвшинд, хэр их аюул занал, асуудал үүсгэж байгаагаас хамаарч хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө ямар өөрчлөлтөнд чиглэх вэ гэдгийг тодорхойлно. Жишээ нь; хүүхдээ байнга зоддог аавтай ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөө нь аавын зан үйлийг өөрчлөх, түүнд хүүхэд хүмүүжүүлэх зэрэг зан үйлийг сургахад чиглэсэн байж болох юм. Нийгмийн ажилтан энэ чиглэлээр ажиллах хэрэгтэй болоход дараах байдлаар кейс төлөвлөгөөг боловсруулах жишээтэй. Кейс төлөвлөгөөний маягтын жишээг Хүснэгт I –ээс харна уу.

Хүүхэдтэй зүй бус харьцсан тодорхой нэг тохиолдол буюу кейстэй ажиллах төлөвлөгөө нь бусад төлөвлөгөөнд тавигдах шаардлагатай адил зорилго, зорилт, үйл ажиллагаанууд нь хоорондоо уялдаа холбоотой байна⁸. Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгаж анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Хүүхэдтэй зүй бус харьцсанаас үүссэн сөрөг нөлөө, тухайн сөрөг нөлөө, эрсдлийн хүчин зүйлийн нөлөөг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны стратегийг гэр бүлийн гишүүдтэй хамтран тогтоох;
2. Нийгмийн ажилтны зүгээс хүүхдийн гэр бүлийн гишүүдэд эрсдэлтэй зан үйл, эрсдлийн хүчин зүйлсийг багасгахад нь чиглэсэн заавар чиглэл өгөх;
3. Үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хүлээгдэж буй үр дүнг хэмжих хэмжилтийн нэгж, хүрээг тодорхой тусгах;
4. Хэлэлцэж буй кейстэй холбоотой шийдвэрийг хэрхэн гаргах чиглэл, зааврыг боловсруулах зэрэг зорилго, чиглэлийг агуулна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зорилгоо оновчтой тодорхойлж, тухайн зорилгын хүрээнд хүрэх зорилт оновчтой, зорилтыг хангах үйл ажиллагаанууд нь тодорхой, хоорондоо холбоотой, нийцсэн байхаар төлөвлөнө.



⁷ А. Батхишиг (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ номны дөрөвдүгээр бүлэг: Хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх нь, хуудас 101. ХИС. УБ: Хөх судар принтинг

⁸ А. Батхишиг (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ номны хуудас 101 – 103

Хүснэгт 1: КЕЙС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ МАЯГТЫН ЖИШЭЭ

Кейсийн код: 0014

Эхлэх хугацаа: 2016 оны 8 сарын 8

Дуусах хугацаа: 2016 оны 10 сарын 15

Нийгмийн ажилтны нэр: А. Чимгээ

Үйлчлүүлэгчийн нэр: Болд (хүүгийн аав), Дулмаа (хүүгийн ээж)

Нийгмийн ажилтан эцэг эхийн зан үйлээ өөрчлөх хүсэл эрмэлзлэл, хүүхдийн аюулгүй байдал болон эрсдлийн хүчин зүйлсийн үнэлгээний үр дүнд тулгуурлан дараах зорилгыг тавьж кейс төлөвлөгөөг хамтран боловсруулсан.

Үйлчилгээний зорилго: Аав, ээж (Болд, Дулмаа) 2 хүүхдүүдтэйгээ ажиллах үр дүнтэй арга барилд суралцан, бие махбодын шийтгэлийг дахин хүүхдээ хүмүүжүүлэх арга гэж хэрэглэхгүй болно.

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах хүн	Нөөц	Биелэлт ⁹
1	Зорилт 1: Болд эхнэр хүүхдүүдийн хамт гэртээ тогтмол дагаж мердөх, энгийн дүрэмтэй болж мердөж эхлэх	1.1 Үйл ажиллагаа Эцэг эх, хүүхэд тогтмол цагт хооллох, унтах, босох, хичээл хийх тухай энгийн дүрэм зохиох	Нийтээр зөвшөөрсөн гэр бүлийн дүрэм Дүрмээ дагаж буйг ноглох тэмдэглэл, баримт Хүүхдийн хичээлийн амжилт	2016 оны 8 сарын 25	Аав Болд, Ээж Дулмаа Нийгмийн ажилтан	Нийгмийн ажилтан, хүүгийн сургуулийн багш нараас зөвлөгөө авах боломжтой.	Эцэг эх хүүхдийн харилцаа сайжирсан эсэх Хүүхдийн хичээл сурлагад өөрчлөлт гарсан эсэх тухай үр дүн
		1.2 Үйл ажиллагаа Эцэг Болд, эх Дулмаа нар нийгмийн ажилтантай хамтран хоёр хүүхдийнхээ нас, бие махбод, сэтгэцийн хөгжлийн түвшинд тохирсон хийж чадах зүйлийг нь тодорхойлох	Хүүгийнхээ нас, бие махбод, сэтгэцийн онцлогийг ойлгодог болох тухай ярьж бичсэн тэмдэглэл	2016 оны 9 сарын 15	Нийгмийн ажилтан, Аав Болд, Ээж Дулмаа	Сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн эмч	Хүүхдийнхээ насны онцлог, нас сэтгэхүйтэй холбоотой өөрчлөлтийг ойлгодог болсон тухай Хүүхдээ ойлгож тэдний харилцаанд гарсан эерэг өөрчлөлтийн тухай мэдээлэл

⁹ Биелэлтийг үйлчилгээний эцэст дүгнэн бичих учир ямар мэдээлэл тухайн үйл ажиллагааны биелэлт байж болох талаар тайлбарыг дараах байдлаар бичнэ.

2	<p>Зорилт 2: Хүүхдийн насны онцлог, хөгжлийн түвшинд тохирсон хүүхдийн эерэг аргуудад суралцах</p>	<p>2.1 Үйл ажиллагаа Ээж, аавыг хүүхдийн эерэг аргын сургалтад хамруулах</p>	<p>Хүүхдийн эерэг хүүхдийн тухай сургалтад суусан тоо, хичээлийн тэмдэглэл</p>	2016 оны 09 сарын 2	<p>Нийгмийн ажилтан Аав Болд Ээж Дулмаа</p>	<p>Сургалт явуулсан багш, хорооны хамтарсан багийн гишүүдтэй ажилладаг ТТБ-ын сэтгэл зүйч</p>	<p>Сургалтад суусан тухай тэмдэглэл, эцэг эхийн хүүхэдтэйгээ харилцах харьцаанд гарч буй өөрчлөлт, ялангуяа бие махбодийн шийтгэлээс зайлсхийх оролдлого хэрхэн хийсэн тухай</p>
	<p>2.2 Үйл ажиллагаа Аав ээж нь хамтран хүүхдийнхээ хамгийн хэцүү зан байдлыг тодорхойлж, түүний энэ сөрөг занг хянахад тохирох хүүхдийн эерэг аргуудаас суралцах</p>	<p>Хүүхдийнхээ зан байдлыг тодорхойлсон тэмдэглэл Хүүхдийнхээ сөрөг занг хянахад ашигладаг арга, оролдлогын тухай тэмдэглэл</p>	2016 оны 9 сарын 25	<p>Ээж Дулмаа, аав Болд, Нийгмийн ажилтан</p>	<p>Нийгмийн ажилтан</p>	<p>Хүүхдийнхээ гаргаж байгаа зан байдлын талаар ээж, аав нь хэрхэн ойлгодог болсон тухай</p>	

Үйлчилгээний буюу кейс төлөвлөгөө боловсруулахад оролцсон :

1. Болд-аав, /
2. Дулмаа-ээж /
3. Нийгмийн ажилтан Чимгээ /
4. Сургуулийн нийгмийн ажилтан Алимаа /
5. Өрхийн эмч Цэцгээ /

Үйлчилгээний төлөвлөгөөний зорилго ба зорилт нь тодорхой, үр дүн ба өөрчлөлт гарах боломжтой, тэдгээр өөрчлөлтийг хэмжиж болохуйц, төлөвлөж буй ажил нь бодитой, тодорхой цаг хугацаанд хийгдсэн байхаар боловсруулна.

Хамтарсан багийн үйлчилгээний төлөвлөгөө нь багийн гишүүд тухайн кейс дээр хэрхэн хамтран ажиллах, ямар үйл ажиллагааг багийн гишүүд багаараа хийх, ямар үйл ажиллагааг гишүүд бие даан тус тусдаа хариуцах талаар ойлгож зөвшилцсөн байна.

Хорооний нийгмийн ажилтан нь кейстэй холбоотой үйлчилгээ, үйл ажиллагааг холбон зохицуулах кейс менежерийн үүргийг ихэвчлэн гүйцэтгэдгийн хувьд кейстэй холбоотой мэдээллийг гишүүдэд дамжуулах, мэдээллийн нууц хадгалах, бусад зохицуулалтыг хийх тухай багийн гишүүдтэй зөвшилцөж төлөвлөгөөндөө тусгана.



III. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРГЭХ

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь 1) хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдийг хамгаалах шуурхай тусламж, үйлчилгээ; 2) хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслах хамгаалах ба нөхөн сэргээх үйлчилгээ; 3) хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэсэн гурван чиглэлээр үзүүлнэ¹⁰. Энэ гурван чиглэлийн үйлчилгээг хүүхэд хамгааллын үйлчилгээний пирамид гэж бас нэрлэдэг.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний пирамид



Зураг. Хүүхэд хамгааллын үйлчилгээний пирамид

Хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдэд үзүүлэх шуурхай тусламж, үйлчилгээ

Хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шуурхай тусламж үйлчилгээ нь тухайн хүүхдийн нөхцөл байдлыг үнэлэх үеэс эхэлнэ. Өөрөөр хэлбэл хүүхэдтэй зүй бус харьцсан, хүүхэд хүчирхийлэл дарамтад өртсөн гэсэн мэдээллийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ хүүхдийн аюулгүй байдал, хүчирхийлэл дарамтыг үүсгэх сөрөг хүчин зүйлсийг эрдслийн үнэлгээгээр хийнэ.

Хүүхэдтэй зүй бус харьцсаны улмаас хүүхэд хэр их бэртэл гэмтэл авсан эсэхийг өрхийн эмч, гэмтэл ба шүүх эмнэлгийн эмчийн тусламжтайгаар тогтооно. Ялангуяа энэ тохиолдолд эмнэлгийн ямар тусламж авах, эмнэлгийн тусламж авахад юуг анхаарах талаар өрхийн эмчийн өгөх зөвлөгөө их чухал.

Хэрэв эцэг эх ба асран хамгаалагчийн хэн нэг нь хүүхэдтэй зүй бус харьцаж хүүхэд гэмтэж бэртсэн, тухайн гэрт байгаа бусад хүүхэд, гэр бүлийн гишүүд хүчирхийлэл үйлдэгчийн дарамт шахалтад байгаа нь илэрвэл нийгмийн ажилтан хамтарсан багийн ахлагч болох Засаг дарга ба бусад хамтарсан багийн гишүүдийн тусламжтайгаар хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангах, тэдний амь нас, эрүүл мэндийг хамгаалах шуурхай арга хэмжээ авна.

¹⁰ А. Батхишиг (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ номны хуудас 107–113

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд ба эмэгтэйчүүдийн амь нас эрүүл мэндэд ноцтой аюул занал тулгарч буй үед тэднийг аюулгүй байранд шилжүүлэх, нөгөө талаас хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах ба тусдаа амьдрахыг даалгах зэрэг арга хэмжээг цагдаа, хүчний байгууллагын дэмжлэгтэйгээр гүйцэтгэнэ.

Хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдийг, ялангуяа бага насны хүүхдийг улсын хамгаалалт, асрамжид авах нь хүүхдийг амь нас эрүүл мэндийг хамгаалах нэг чухал арга хэмжээ. Гэхдээ бага насны хүүхдийг эцэг эх асран хамгаалагчаас нь тусад нь халамж, асрамжийн газар удаан хугацаагаар байлгах нь хүүхдийн хөгжил, нийгэмшилд хор хөнөөл учруулдаг гэсэн судалгаа байдаг. Иймээс, хүүхдийг гэр бүлийн орчноос нь тусдаа халамж, асрамжийн газарт байлгах нь хүүхдийг хамгаалах **хамгийн эцсийн арга хэмжээ** гэж хүүхдийн эрхийн байгууллагууд үздэг.

Тиймээс хүүхдийг халамж, асрамжийн газар шилжүүлсэн тохиолдолд түүнийг гэр бүлд нь хэзээ, хэрхэн эргэн нэгтгэх, гэр бүлийн аюулгүй тайван байдлыг бий болгоход чиглэсэн ямар үйл ажиллагааг явуулах хэрэгтэйг мөн бодох хэрэгтэй болно.

Хүүхэд ба гэр бүлийн гишүүд хүчирхийлэл дарамтад өртөхөд бие махбод, эрүүл мэндийн хувьд гэмтэж бэртэх, бие эрхтний үйл ажиллагаа хэвийн биш байдалд орохоос гадна хохирогч хүүхэд, гэр бүлийн гишүүд сэтгэл зүйн хүчтэй дарамт, цочролд өртдөг. Иймээс нийгмийн ажилтны зүгээс хохирогч хүүхэд болон гэр бүлийн гишүүд сэтгэл санааны хямрал, цочролоо даван туулахад нь туслах үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх хэрэгтэй болно.

Үйлчлүүлэгчийнхээ¹¹ сэтгэл санааны хямрал, цочролыг даван туулахад туслах хамгийн эхний алхам бол үйлчлүүлэгчийнхээ нөхцөл байдлыг сайтар ойлгож, сэтгэл санааны цочрол болон хямралд хүргэсэн шалтгааныг мэдэх явдал юм.

Мөн үйлчлүүлэгчтэй харилцаа холбоогоо хөгжүүлж, үйлчлүүлэгчид төрж буй айдас түгшүүр, санаа зовоож буй асуудлыг ойлгох, түүнд тулгарч буй хэрэгцээнд нухацтай анхаарал хандуулна¹². Үйлчлүүлэгчтэй харилцаа холбоогоо бэхжүүлэх замаар түүнд тулгарч буй асуудлыг тэрээр юу гэж ойлгож байгааг мэдэж, хямрал, цочролтой холбоотой үүссэн айдас түгшүүр ба бодит байдлын ялгааг үйлчлүүлэгч олж харахад нь тусална. Улмаар үйлчлүүлэгч асуудлыг даван туулах чадвартай гэсэн итгэл найдварыг бий болгох нь их чухал.

Хэрэв үйлчлүүлэгч хэт их айдас түгшүүртэй, сэтгэцийн хямралын шинж тэмдгүүд хүчтэй илэрч байгаа тохиолдолд түүнийг сэтгэцийн эрүүл мэндийн эмч, мэргэжилтэнтэй холбон зуучилж үйлчилгээ авахад нь тусална. Хямралын интервенцийн үе шат, онцлогийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг А. Батхишиг нарын (2009) Хүүхэд хамгааллын үйлчилгээ номны «Хүүхэдтэй зүй бус харьцах явдал: Судалгаа, онолын асуудлууд» гэсэн хоёрдугаар бүлгээс уншина уу.

¹¹ Үйлчлүүлэгч гэдэгт хүчирхийлэл дарамтад өртсөн хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, хохирогчийн ах эгч дүү нар хамаарна. Харин хүчирхийлэл үйлдэгч гэдэгт хүчирхийлэл, дарамт үйлдсэн ба үйлдэхийн завдсан гэр бүлийн хэн нэг гишүүн, эсвэл тухайн гэр бүлийн биш гадны хүн багтана.

¹² Johnson, L.C., (1995). Social work practice: A generalist approach, 5th ed, Needham Heights MA: Allyn Bacon.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлийг хамгаалах, тэднийг хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслах хамгаалах ба нөхөн сэргээх үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний гэр бүлтэй ажиллах үйл явц нь тэдэнд туслах шуурхай, яаралтай тусламжаар хязгаарлагдахгүй. Ялангуяа хүүхэдтэй зүй бус харьцсаны улмаас бие махбод болон сэтгэл санааны хүнд гэмтэл авсан хүүхдийн сэтгэл санаа тогтворгүй болох, айдас түгшүүртэй, бусадтай харилцах харилцаанд нь өөрчлөлт орох магадлал өндөр байдаг. Мөн тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хувьд урьдын адил ажил амьдралаа хэвийн үргэлжлүүлэхэд хүндрэл гарах явдал түгээмэл. Тиймээс нийгмийн ажилтан хүүхэдтэй зүй бус харьцах явдалд өртсөн хүүхэд, тэдний эцэг эх асран хамгаалагч, гэр бүлийн бусад гишүүдтэй ажиллах хэрэгтэй болно. Хамгаалах ба нөхөн сэргээх үйлчилгээний хэлбэрүүдийг¹³ нэмж уншаарай.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэрүүдээс хүүхдийн бие махбодын гэмтэл, сэтгэцийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийг эмчлэхэд өрхийн эмч болон хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн эмнэлэгийн үйлчилгээг авна. Хамтарсан багийн гишүүн болох өрхийн эмчийн туслалцаа нь бие махбод болон сэтгэл санааг эмчлэх, зөвлөн туслах улмаар нарийн мэргэжлийн эмчтэй холбох, шаардлагатай шинжилгээ хийлгэх зэрэг үйлчилгээг үзүүлэхэд нэн чухал. Нийгмийн ажилтны зүгээс эцэг эх, асран хамгаалагчид эмнэлгийн үзлэг шинжилгээний зардлын төлбөрөө олоход нь туслах, халамжийн болон бусад тусламжийн байгууллагатай холбон зуучлах зэрэг боломжтой нөөцтэй холбох үүрэг гүйцэтгэнэ.

Хамтарсан багийн гишүүн болох хэсгийн байцаагчийн хувьд хүүхэд дахин бие махбод, сэтгэл санааны дарамт хүчирхийлэлд өртөхгүй байх, хүүхдийн гэр бүлийн болон нийгмийн орчинд хүчирхийлэл дахин үйлдэгдэхгүй байхад анхаарал хандуулна. Үүнтэй холбоотой Хан-Уул дүүргийн 10 хороонд анх хэрэгжүүлж байсан хамтарсан багийн сайн туршлагыг дурдаж болно. Энэ санаачлагыг хорооны нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдийн оролцоотойгоор анх гаргасан бөгөөд тэд хорооны айл өрхийн судалгаа гаргах явцдаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй хүүхэд эмэгтэйчүүдийн судалгааг гарган, тэдний гэрийн байршлыг тогтоон тэдгээр айл өрхөд хамтарсан багийн гишүүд илүү анхаарал хандуулж ажилладаг байжээ.

Хүүхэдтэй зүй бус харьцсаны улмаас хүүхдийн зан авир, хичээл сурлагад гарсан өөрчлөлтөд чиглэсэн үйлчилгээг хорооны нийгмийн ажилтан дангаараа, мөн сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн нийгмийн ажилтнууд хамтран хүргэнэ. Хүүхдийн зан үйлд гарсан өөрчлөлтөд чиглэсэн үйлчилгээг хүргэхдээ нийгмийн ажилтан нь зан үйлийн болон танин мэдэхүйн онолуудыг ашиглана.

Тухайлбал, хүүхэдтэй зүй бусаар харьцсаны улмаас хүүхэд болон тэдний эцэг эхэд төрсөн таагүй мэдрэмж, сөрөг бодлыг таслан зогсоохын тулд нийгмийн ажилтан юуны өмнө тухайн үйлчлүүлэгчид төрж буй сөрөг бодол нь юунаас эхтэй, ямар итгэл үнэмшил дээр тулгуурлаж байна, нөгөө талаас тэр сөрөг бодолтой холбоотой ямар зан үйл илэрч байгааг үйлчлүүлэгчтэй хамтран ажиллах үедээ тогтооно. Өөрөөр хэлбэл сөрөг бодол, зуршил нь өнгөрсөн цаг хугацаатай холбоотой. Шинэ зүйлийг, шинэ зан үйлийг одоо сурч болно гэж үйлчлүүлэгчид ойлгуулахад гол анхаарлаа хандуулна.

¹³ А. Батхишиг нар, (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ, хуудас 107–113

Ингэж үйлчлүүлэгчийн итгэл үнэмшил, бодол санаа ба зан үйлийг задлан шинжилснээр үйлчлүүлэгч өөрийн гаргаж буй сөрөг зан авир, үйлдлээ хянахад туслах, мөн үйлчлүүлэгчид төрсөн сөрөг бодол санаа, итгэл үнэмшил нь хэр бодитой байгаа, сөрөг бодол санаа нь ямар үр дагаварт хүргэж болох, сөрөг бодол, итгэл үнэмшлээ хэрхэн зогсоох талаар ярилцах боломжтой болно. Энэхүү зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн үйлчилгээний арга техникийг сэтгэл санааны хямрал цочролын улмаас байнга сөрөг бодол тээж байгаа, элдэв хорт зуршил, сөрөг дадалтай үйлчлүүлэгчтэй ажиллахад ашиглахад нэн тохиромжтой. Хэрэв хорт зуршил, сөрөг дадал зуршлын улмаас үйлчлүүлэгчийн бие махбодод эмгэг өөрчлөлт илэрсэн бол сэтгэцийн эрүүл мэндийн эмч, сэтгэл зүйчийн туслалцааг авах шаардлагатай.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчийн зан үйлийн өөрчлөлтөд чиглэсэн үйлчилгээ нь гэр бүлийн гишүүдийн эерэг харилцааг бэхжүүлэх, гэр бүлийг дэмжих ба хамгаалах үйл ажиллагаатай хамт хийгдэхэд илүү үр дүнтэй. Эерэг харилцааг бэхжүүлэхэд гэр бүлийн гишүүдийн дунд хэвшүүлэхээр зорьж буй эерэг зан үйлийг гэр бүлийн гишүүдтэй хамтран тодорхойлж тэр зан үйлийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна. Мөн сөрөг зан үйлийг зогсооход чиглэсэн тодорхой зорилго бүхий үйл ажиллагааг явуулж, гарсан эерэг өөрчлөлтийг сайшаан тэмдэглэж, сөрөг зан үйлийн урьдал нөхцөл, үр дагаварыг хэлэлцэж дүгнэлт хийнэ.

Гэр бүлийг дэмжих үйл ажиллагаанд эцэг эхийн хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх мэдлэг чадвараа хөгжүүлэхэд туслах, олон нийтийн нөөц боломжинд түшиглэн гэр бүлд чиглэсэн үйлчилгээг хүргэх, гэр бүлийн гишүүдийн үүргээ биелүүлэхэд туслах зэрэг үйлчилгээ багтана¹⁴. Харин гэр бүлийг хамгаалах үйлчилгээнд хүчирхийлэлд өртсөн ба өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, гэр бүлийн эерэг харилцаа холбоог бэхжүүлэх, хямралыг даван туулах, гэр бүлд туслах албан ба албан бус дэмжих тогтолцоог дэмжих зэрэг үйл ажиллагаанууд багтана.

Жонсоны тодорхойлсноор дэмжих үйл ажиллагаа нь дараах дөрвөн хэлбэртэй байдаг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчийг зөвлөн чиглүүлэх, түүнд тулгарсан саад бэрхшээлд хязгаар тогтооход туслах хамгаалах үйл ажиллагаа;
2. Үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг маш сайн ойлгож, түүний үнэ цэнийг мэдрүүлэх хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа;
3. Үйлчлүүлэгчид хэрхэн үр дүнтэй ажиллах, даван туулах тухай заах гэх мэт сургах үйл ажиллагаа;
4. Үйлчлүүлэгч өөрчлөлт хийх чадвартай гэдгийг ойлгуулах, түүний даван туулах гүйцэтгэлийг бататгахад чиглэсэн нотлох үйл ажиллагаа тус тус багтана.

Тиймээс эдгээр хэлбэрүүдийн аль хэлбэр нь хүчирхийлэл ба дарамтанд өртсөн хүүхэд болон түүний гэр бүлийн гишүүнд тохирох эсэхийг сонгон дэмжих үйлчилгээг үзүүлнэ. Дэмжих эдгээр үйлчилгээний тухай хамтарсан багийн бусад гишүүдэд мэдээлж тэдэнтэй хамтран хүүхэд болон түүний гэр бүлийг олон талаас нь дэмжин туслах шаардлагатай.

Хамтарсан багийн кейс менежер—нийгмийн ажилтан нь байнгын хүчирхийлэл, дарамтын улмаас өөрийгөө хүчин мөхөс, сул дорой гэж боддог, өөртөө итгэлгүй хүүхэд, эмэгтэйчүүдтэй ажиллахдаа чадваржуулах арга техникийг ашиглана.

¹⁴ Т. Цэндсүрэн (2012). Хүүхэд гэр бүлд түшиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага. хуудас 93–97.

Чадваржуулна гэдэг нь үйлчлүүлэгчид боломж олгох нэгэн хэлбэр бөгөөд үйлчлүүлэгчийг өөртөө итгэлтэй, эрх мэдэл, хүч чадалтай болгох, олж авсан эрх мэдэл, хариуцлагаа хүлээх мэдлэг чадвартай болгоход чиглэсэн үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл эрх мэдэл, хүч чадалгүй байна гэдэг нь өөрийн амьдарч, сурч, ажиллаж байгаа газрынхаа талаарх мэдээлэл, мэдлэг дутмаг, түүнийг хүрээлэн буй хүмүүс, байгууллага, нийгмийн тогтолцоотой зөвшилцөх мэдлэг, чадвар сул байгаатай холбоотой гэж үздэг.

Тиймээс үйлчлүүлэгчийг дэмжих, түүнийг дэмжих орчин нөхцөл, дэмжлэг авах аргыг түүнд зааж сургах, өөртөө итгэлтэй байдлыг нь дэмжихэд чадваржуулах арга чиглэдэг.

Чадваржуулах стратегийн зарим нэг онцлогоос дурдвал нийгмийн ажилтан нь үйлчилгээнийхээ бүхий л үе шатанд үйлчлүүлэгчийг дээд зэргээр оролцуулахад анхаарлаа хандуулах, үйлчлүүлэгчээ хүндэтгэх, харилцан итгэлцлийг бий болгох, үйлчлүүлэгч өөрийгөө буруутгах явдлыг багасгахад туслах, үйлчлүүлэгч өөрт тохиолдсон асуудлыг орчны, тогтолцооны доголдолтой үйл ажиллагаатай холбоотой гэдгийг олж харахад нь туслах гэсэн стратеги байна.

Үүний тулд үйлчлүүлэгч нөхцөл байдлын тухай бодит мэдээлэл өгөх, бусадтай харилцах харилцаа холбооны чухлыг ойлгуулах, үйлчлүүлэгчийн өөртөө итгэлтэй байдлыг нэмэгдүүлэхэд анхаарна.

Хүүхэд хамгааллын хамгаалах ба нөхөн сэргээх үйлчилгээ нь хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхэд болон гэр бүлийн гишүүдийн бие махбод, сэтгэл санааны гэмтэл бэртлийг эмчлэн эдгээх, цаашилбал тэд хичээл ном, ажил амьдрал, нийгмийн амьдралд урьдын адил оролцох, нийгмийн идэвхтэй гишүүн болоход туслах цогц үйлчилгээ юм. Бүх оролцогч талуудын тухайлбал нийгмийн ажилтан, хамтарсан багийн бусад гишүүд, хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдийн идэвхтэй оролцоо, хүчин зүтгэлийн дүнд энэ үйлчилгээ нь үр дүнтэй болно.

Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, тэдний гэр бүлийг нийгмийн амьдралд эргэн ороход тэднийг туслан дэмжих гэр бүл, хамт олон, байгууллага, олон нийтийн зэрэг нааштай хандлага, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох чин эрмэлзлэл маш чухал. Тиймээс хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлыг таслан зогсоох, хүүхдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх ажил нь нийгмийн ажилтан түүний хамтран зүтгэгчдийн дараагийн хийх ёстой чухал ажил болдог.



Хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас урьдчилан сэргийлэх

Хамтарсан багаас хийгдэх хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас урьдчилан сэргийлэх ажил нь нийгмийн бүхий л давхарга, бүлгийн бүх насны хүмүүсийг хамарна. Хүүхдийг хүрээлэн буй бүх орчин, тухайлбал гэр бүл, цэцэрлэг, сургууль, халамж, асрамжийн төв, дугуйлан, гудамж талбай, амралт сувилал гэх бүхий л орчинд хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлаас сэргийлэх сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй болно.

Ер нь урьдчилан сэргийлэх ажилд хамтарсан багийн гишүүдийн оролцоо маш их чухал. Хамтарсан багийн гишүүд өөрсдийн ажил, мэргэжил, байгууллагын хүрээнд хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас хэрхэн сэргийлэх, хэрэв ямар нэг сэжигтэй ба хүчирхийллийн шинж илэрвэл хэнд, яаж мэдээлэх тухай тодорхой мэдээллийг өгч чадна.

Нөгөө талаар хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогтой холбон тодорхой зорилтот бүлгүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар явуулж болно. Тухайлбал, сургуулийн өмнөх насны хүүхдүүд, тэдний эцэг эхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг хүүхдийн цэцэрлэг, сувилал, хүүхэд харах үйлчилгээний багш, ажилтнууд, эцэг эхтэй хамтран хэрэгжүүлнэ.

Харин сургуулийн насны хүүхдүүд, тэдний эцэг эхэд зориулсан хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчид, эцэг эхийн холбоо, зөвлөлүүдтэй хамтран хэрэгжүүлж болно. Эдгээр хөтөлбөрүүдэд цэцэрлэг, сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг хүчирхийлэл дарамтаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, эдгээр үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог утга төгөлдөр, аюулгүй байдлаар хангах тухай сэдвүүдийг багтаана.

Хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэхэд хүүхдийн эерэг хүмүүжлийн аргуудыг түгээх нь чухал ач холбогдолтой. Эцэг эх, асран хамгаалагчид хүчирхийллийн бус аргаар, бие махбодийн шийтгэл амсуулахгүйгээр хүүхдийг хэрхэн хүмүүжүүлж болох тухай арга техникт суралцаж, энэ аргыг хэрэглэснээр хүүхэд бага наснаасаа эхлэн өөртөө итгэлтэй, өөрийгөө болон бусдыг хүндэлдэг, аливаа зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийддэг арга барилд суралцаж эхэлнэ. Өөрөө хэлбэл хүүхдийн гэр бүл, сургууль, нийгмийн орчин хүчирхийллээс ангид байх эхлэл тавигдана. Тиймээс бүх насны хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчдэд хүмүүжлийн эерэг аргын ач тусыг ойлгуулах, тэднийг энэ арга барилд сургахад нийгмийг өөрчлөгч болохынхоо хувьд нийгмийн ажилтан манлайлах үүргээ гүйцэтгэх ёстой.

Хүүхэдтэй зүй бусаар харьцах явдлаас сэргийлэх ажил нь нийгмийн бүхий л давхарга, бүлэгт хамаарах ажил учраас нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдтэйгээ хамтран орон нутгийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага тулгарна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр хөгжүүлэх орон нутгийн түншлэлийн хөтөлбөр нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийт, иргэдийн анхаарлыг хүүхэд хамгааллын асуудалд хандуулах, хөрөнгө мөнгө босгох, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн хүүхэд хамгааллын үйлчилгээг бий болгох, олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх гэх мэт олон асуудалд бүхэлд нь ба хэсэглэн чиглэсэн байна. Өөрөөр хэлбэл, хүүхэд хамгааллын асуудал бол хүн бүрийн анхаарал хандуулах асуудал мөн гэсэн санаа нь түншлэлийн хөтөлбөрийн гол агуулга болно.

IV БА V. ХҮҮХЭД ХАМГААЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ БА ХААХ

Нийгмийн ажилтан нь мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнийхээ хувьд үйлчлүүлэгч, нийгмийн ажлын мэргэжил нэгт нөхөд ба нийгмийн өмнө ёс зүйн хариуцлага хүлээдэг. Тиймээс нийгмийн ажлын үйлчилгээг хэрхэн үр дүн, үр ашигтай хүргэсэн эсэхийг үйлчилгээний бүхий л шатанд үнэлэх шаардлагатай. Нийгмийн ажлын үйлчилгээний үр дүнг үнэлэхдээ тухай үйлчилгээ нь тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлдэг бол үр ашгийг үнэлэхдээ үйлчилгээний үнэ өртөг, зарцуулж буй хугацаа, үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо, үзүүлж буй үйлчилгээний тоо, хэлбэртэй холбон үнэлнэ.

Нийгмийн ажлын үйлчилгээг үнэлэх олон аргууд байдаг. Эдгээр аргуудад нийгмийн ажлын үйлчилгээний тэмдэглэлд дүн шинжилгээ хийх, үйлчилгээний болон үйлчлүүлэгчийн талаарх тоо баримт, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлтийг ажиглах, тест сорил авах, асуумж судалгаа явуулах, ярилцлага хийх, үйлчлүүлэгчийн тайланд дүн шинжилгээ хийх зэрэг багтана. Нийгмийн ажлын үйлчилгээний үр дүн, үйл явцыг үнэлэхэд үйлчлүүлэгчтэй ажилласан кейс файлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргыг өргөн ашигладаг. Эдгээр аргуудыг үйлчилгээний бүхий л үе шатанд хэрэглэж болно.

Нийгмийн ажлын үйлчилгээний тэмдэглэл буюу үйл явцын тэмдэглэл хөтлөх нь олон талын ач холбогдолтой. Эдгээрээс дурдвал: нийгмийн ажлын үйлчилгээ, үйл ажиллагааны баримт нотолгоо болох, үйлчилгээ тасралтгүй үргэлжлэх боломж олгох, санхүүгийн баримт нотолгоо болох, үйлчилгээний чанарыг хянах хэрэгсэл болох, нийгмийн ажилтны кейсийн талаарх бодол, санааг цэгцлэх, мэргэжилтнүүдийн харилцааны хэрэгсэл болох, судалгаа ба сургалтын үнэт мэдээллийг агуулах, үйлчилгээ үзүүлсэн тухай хуулийн нотолгоо болох зэрэг олон ач холбогдолтой. Иймээс үйлчлүүлэгчтэй ажилласан тухай кейс файлд агуулагдах мэдээлэл нь бүрэн бүтэн, эмх цэгцтэй, мэргэжлийн түвшинд бичигдсэн байх шаардлагатай. Үйл явцын тэмдэглэлийн хэд хэдэн загвар байдаг. Энэ удаад та бүхэнд асуудалд чиглэсэн SOAP тэмдэглэлийн загварыг танилцуулж байна. SOAP гэдэг нь субъектив, объектив, анализ дүн шинжилгээ ба төлөвлөлт гэсэн англи үгний эхний үсгээс бүрдсэн. Асуудалд чиглэсэн SOAP тэмдэглэлийн загварыг Хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 2: Асуудалд чиглэсэн SOAP тэмдэглэлийн маягт

Асуудалд чиглэсэн SOAP тэмдэглэлийн маягт

Огноо:

Үйлчлүүлэгчийн нэр: Харилцах утас:

Нийгмийн ажилтны нэр: Харилцах утас:

Үйлчлүүлэгчийн үйлчилгээ авах хүсэл эрмэлзэл, сэдэл: Өндөр Дунд Бага

Субъектив илтгэл: (Ярилцлагын ерөнхий агуулга, үйлчлүүлэгчийн илэрхийлсэн бодол санаа, мэдрэмжийг бичих)

Объектив илтгэл: (Нийгмийн ажилтны ажиглалт, үнэлгээгээр илэрсэн зан үйл, үйл ажиллагаа, гадаад байдал, хандлага гэх мэт)

Нөхцөл байдлын үнэлгээ: (Давуу тал, онцлог зүйл, тулгарч буй асуудлын хөдлөл зүй, санаа зовоож буй чухал асуудал гэх мэт)

Төлөвлөгөө: (Гэрийн даалгавар, эмчилгээний төлөвлөгөө, дараагийн уулзалтын зорилго, стратеги гэх мэт)

Нийгмийн ажлын үйлчилгээг төгсгөх үйл явц нь үйлчилгээг эхлүүлэхтэй адил үйлчлүүлэгчид чухал нөлөөтэй. Жонсоны тодорхойлсноор үйлчилгээг төгсгөх үйл явцыг гурван үе шатаар удирдана.¹⁵ Үүнд:

1. Харилцаа холбоогоо бага багаар холдуулах үе. Энэ үед үйлчилгээ дуусч байгаатай холбоотой асуудлыг бодитоор харах, өмнө нь хэн нэгэнтэй харилцаа холбоогоо тасалж, салж байсан тухай илэн далангүй ярилцах ба үйлчлүүлэгчийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг ойлгож байгааг илэрхийлнэ.
2. Өөрчлөлтийг тогтоон барих үе. Өмнөх уулзалтуудад болсон үйл явдлыг эргэн дүгнэх нь үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт, хөгжил дэвшлийг харж, цаашид тогтоон хэвшүүлэх тухай ярилцахад тустай. Үйлчлүүлэгчийн эерэг өөрчлөлт, өөртөө итгэх итгэл найдварыг урамшуулан дэмжинэ.
3. Үнэлэх үе. Үйлчилгээг үнэлэх үйл явц нь зөвхөн үйлчилгээг хаах шатанд хийгдэхгүй, үйлчилгээний бүхий л шатанд хийгдэнэ. Хаалтын шатны үнэлгээний гол зорилго нь үйлчилгээний төлөвлөгөөний зорилго, зорилтууд биелсэн эсэхэд анхаарал хандуулна. Хүрсэн амжилт, хүрч чадаагүй зүйл юу байсан тухай хэлэлцэнэ. Үйлчлүүлэгчийн амжилт, алдаа оноог гаргах болсон үйл явцыг хэлэлцэх нь үйлчлүүлэгчийн өсөлт хөгжил, нийгмийн ажилтны цаашдын үйлчилгээнд сургамж болох чухал ач холбогдолтой.

Нийгмийн ажлын үйлчилгээг үнэлэх ба хаах үйл явц нь үйлчлүүлэгчтэй байгуулсан үйлчилгээний гэрээ буюу төлөвлөгөөний үр дүнг үнэлэх үйл явц. Үйлчилгээний хаалтын үйл явцыг тусад нь тодорхой тогтсон маягын дагуу тэмдэглэж, үйлчлүүлэгчийн кейс файлд хийнэ. Кейс хаах маягыг ХТҮГ-ын даргын 2016 оны 4 сарын 13-ны өдрийн А/42 тушаалаар батлагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээний маягтаас харна уу.

Хаах үйл явцад тухайн үйлчилгээг хүргэхэд оролцсон хамтарсан багийн гишүүд ба үйлчилгээг хүртсэн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүд оролцож болно. Гэхдээ үйлчилгээний үр дүнг хэлэлцэх үйл явц нь үйлчлүүлэгч болон хэн нэгнийг шүүмжлэх байр сууринаас биш, амжилтаа бататгах, алдаа оноон дээрээ суралцах гэсэн эерэг хандлагаар асуудалд хандахыг шаардана.

¹⁵ А.Батхишиг нар (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ, хуудас 177

НИЙГМИЙН АЖИЛТАН ӨӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ НЬ

Аюулгүй байдлаа хангах тухай

Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл гарсан гэсэн дуудлагын мөрөөр нөхцөл байдал, эрсдлийн үнэлгээ хийхээс өмнө очих айл, газрынхаа талаар нарийвчлан судалж, гарч болох эрсдэл, аюулын тухай хамтран ажиллах хамтарсан багийн гишүүн, мэргэжил нэгт нөхөдтэйгээ ярилцана. Хэрэв дуудлагын мэдээ болон очих айл, газрын талаарх мэдээлэл нь аюултай, эрсдэл өндөртэй гэсэн тохиолдолд хэсгийн байцаагч болон хамтарсан багийн бусад гишүүдтэй хамт тухайн айлд очих хэрэгтэй.

20 дугаар зүйл. Нийгмийн ажилтны эрх зүйн байдал

- 20.1. Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, дүүрэг, баг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.
- 20.2. Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, түүнд тавигдах шаардлагыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн холбоодтой зөвшилцөн батална.
- 20.3. Нийгмийн ажилтан нь хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа талаарх мэдээлийг хүлээн аваад тухайн газар дээр очиж шалгах, тухайн хүүхэдтэй нөхцөл байдлын талаар харилцан ярилцах, хуулиар хориглоогүй мэдээлэл цуглуулах эрхтэй.
- 20.4. Нийгмийн ажилтан өөрийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөлд хүүхдэд эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх шаардлагатай болсон тохиолдолд цагдаагийн байгууллагын туслалцааг авна.
- 20.5. Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хариуцна.

Хүүхэд хамгааллын тухай хууль

Нөхцөл байдлын үнэлгээ хийхээр явахдаа өөрийн удирдах ажилтан, мэргэжил нэгт нөхөртөө хаашаа, хэнтэй хамт явах тухайгаа амаар эсвэл бичгээр мэдэгдэнэ. Үнэлгээ хийхээр явахдаа үнэт зүйлс, их хэмжээний мөнгө, чухал баримт бичиг авч явахаас зайлсхийх нь зүйтэй. Үйлчлүүлэгч ба хохирогчийн талаарх мэдээлэл, кейс файлыг ажлын байранд аюулгүй газар үлдээнэ.

Нөхцөл байдлын үнэлгээ хийх айлд аль болох өдрийн цагаар очихоор төлөвлөнө. Хэрэв гэр бүлийн гишүүд таньтай ярилцах дургүй, айлган сүрдүүлэх тохиолдолд айлыг даруйхан орхин явах хэрэгтэй. Галт зэвсэг, хутга мэс барьсан хүнээс нэн даруй тайван замаар зугтан, салахыг хичээнэ. Ажлаа гүйцэтгэх явцад өөрийн аюулгүй байдалдаа анхаарч, асуудал хурцдах, аюул тулгарахад удирдлагадаа шуурхай мэдэгдэж аюулгүй байдлаа хангах, аюулгүй газар очих хэрэгтэй.

Ажил амралтын тэнцвэртэй байдлаа хадгалах

Нийгмийн ажилтан бусдад туслахын тулд эхлээд өөрийн сэтгэл санаа, ажил амралтын тэнцвэртэй байдалд зайлшгүй анхаарах хэрэгтэй. Үүний тулд өөрийгөө ойлгох, өөрийгөө сонсох, өөрийн боломж хязгаараа мэдэх, шаардлагатай тохиолдолд бусдаас тусламж хэрхэн хүсэх тухай мэдэх хэрэгтэй болно.

Нийгмийн ажилтан ажил дээрээ баримтлах дүрэм зарчмаа тодорхойлж, хувийн зохион байгуулалтандаа анхаарах нь ажлаас үүдэлтэй дарамт, шахалтыг багасгахад тус болно. Эцэст нь хэлэхэд нийгмийн ажилтан өөрийн ажил, амьдралын орчноо сайтар судалж, өөрт туслах албан ба албан бус дэмжлэгийн тогтолцоог таньж, бэхжүүлснээр ажил, амьдралтай холбоотой дарамт, саад бэрхшээлийг бусадтай хамт, тэдний дэмжлэгээр даван туулах боломж нөхцлийг олж нээнэ.

Нэмж судлах материал: А. Батхишиг нарын (2009) Хүүхэд хамгааллын үйлчилгээ номны «Хүүхэдтэй зүй бус харьцах явдал, түүний хэлбэрүүд, Хүүхэд хамгааллын үйлчилгээ зэрэг бүлгүүд; А. Батхишиг нарын (2008) Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх нь зэрэг номноос нийгмийн ажлын үйлчилгээ, нөхцөл байдлын үнэлгээний хэлбэр, нарийвчилсан зааврыг дэлгэрүүлэн уншина уу.



НОМ ЗҮЙ

- А. Батхишиг, Х. Өлзийтунгалаг (2008). Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь: Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага. ХЭҮТ, УБ: Бит Пресс. ХХК
- А. Батхишиг, Н. Нямдорж, О. Мягмар (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ: Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага. ХИС ба Accenture. УБ: Хөх судар принтинг ХХК.
- М. Воодсайд, Т. Маклам, С. Вильсон (2003, 2007). Нийгмийн ажил: Кейс менежмент ба үйл явцын тэмдэглэл. УБ: Копир Тех, ХХК
- Г. Түмэннаст, Т. Бүрэнжаргал, Н. Болдмаа, М. Батбаатар, Ц. Одгэрэл, Д. Оюунцэцэг, С.Түмэндэлгэр (2015). Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал: *Судалгааны тайлан*. Save the Children Japan, DIPR.
- Т. Цэндсүрэн (2012). Хүүхэд гэр бүлд түшиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага. хх 93–97. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн тулгамдсан асуудлууд: Онол практикийн бага хурал. УБ: ХТҮГ
- IFSW (2014). *Global Definition of Social Work*. Retrieved from <http://ifsw.org/get-involved/global-definition-of-social-work/>

ХАВСРАЛТ I**Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4, 5 ба 19 дүгээр заалтууд¹⁶****4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1. Энэ хуульд заасан дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг;

4.1.2. “нийгмийн ажилтан” гэж баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг;

4.1.3. “хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг;

4.1.4. “хууль зөрчсөн хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг;

4.1.5. “хамтарсан баг” гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг;

4.1.6. “хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг;

4.1.7. “хүүхдийн эрхийн ажилтан” гэж хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтныг;

4.1.8. “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг.

5 дугаар зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал

5.1. Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна.

5.2. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж,

¹⁶ УИХ (2016). Хүүхэд хамгааллын тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Эрх зүйн акт– Монгол Улсын хууль. <http://legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>

түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

5.3. Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үзүүлнэ.

5.4. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

19 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны хүүхэд хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагаа

19.1 Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.1.1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хариу үйлчилгээнд хамруулах;

19.1.2. Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх;

19.1.3. Нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;

19.1.4. Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, дуусах хүртэл хүүхдийг хамгаалах;

19.1.5. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомж зөрчсөн талаар мэдээлэх, уг зөрчлийг арилгуулахаар шаардлага бичих;

19.1.6. Эрсдэлт нөхцөлд байгаа, хууль зөрчсөн хүүхдийн талаар бүртгэл, судалгаа хийх, орон нутгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;

ХАВСРАЛТ 2**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар заалт¹⁷****10 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх нийгмийн ажилтны үүрэг**

10.1. Нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ;

10.1.1. Тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох;

10.1.2. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж, энэ хуулийн 7.3.2–т заасан хөтөлбөрийн дагуу явуулах;

10.1.3. Хохирогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын туслалцаатайгаар явуулах;

10.1.4. Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи тайлан мэдээ гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн холбоотой мэдээллийн сүлжээ бий болгоход оролцох.

¹⁷ УИХ (2004). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Эрх зүйн акт– Монгол Улсын хууль, <http://legalinfo.mn/law/details/227?lawid=227>

ХАВСРАЛТ 3:**Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 ба 15 дугаар заалтууд¹⁸****7 дугаар зүйл. Хүүхдийн хамгаалуулах эрх**

7.1. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.

7.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

7.3. Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.

7.4. Хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

7.5. Хүүхдийн хамгаалагдах эрхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үүрэг, оролцоо

15.1. Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ажилтан нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1. тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.1.2. тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих;

15.1.3. эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

15.1.4. хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

15.1.5. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн тухайн шатны байгууллага, ажилтан нь хүүхэд, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвлөгөө, мэдээллээр хангах, шаардлагатай бол сургалт зохион байгуулах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжиж, арга зүйн удирдлагаар хангах;

15.1.6. энэ хуулийн 14.2–т заасан журмын дагуу анхан шатны байгууллага, ажилтан, хамтран ажиллаж байгаа хуулийн этгээдээс мэдээ тайлан авч, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хянах, холбогдох мэдээллийг нэгтгэн төв байгууллагад хүргүүлэх;

15.1.7. хүүхэд гишүүнчлэлтэй болон эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг төрөөс дэмжин, байр, танхимаар хангах;

¹⁸ УИХ (2016). Хүүхдийн эрхийн тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Эрх зүйн акт– Монгол Улсын хууль . <http://legalinfo.mn/law/details/11709?lawid=11709>

ХАВСРАЛТ 4**Халамжийн тухай хуулийн 13, 14 ба 28 дугаар заалтууд¹⁹****13 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэмж**

13.1. Нийгмийн халамжийн тэтгэмж /цаашид “тэтгэмж” гэх/ дараах төрөлтэй байна:

13.1.1. асаргааны тэтгэмж;

13.1.2. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж;

13.1.3. онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж;

13.1.4. жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж.

13.2. Асаргааны тэтгэмжийг дараах иргэнд олгоно:

13.2.1. бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;

/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар “бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон” гэсний дараа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг” гэж нэмэлт оруулсан бөгөөд үүнийг 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

13.2.2. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар “гэр бүлдээ авч асрамжилж байгаа” гэсний дараа “хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа” гэж нэмэлт оруулсан бөгөөд үүнийг 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/

13.5. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно:

13.5.1. гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх;

13.5.2. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн;

13.5.4. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;

/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

13.5.5. энэ хуулийн 19.2.4-т зааснаас бусад хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэн;

13.5.6. байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг.

/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

¹⁹ УИХ (2012). Нийгмийн халамжийн тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Эрх зүйн акт – Монгол Улсын хууль, <http://legalinfo.mn/law/details/393?lawid=393>

- 13.5.7. байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн;
- 13.5.8. гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/;
- 13.5.9. “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон, эсхүл “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонтой эх мөнгөн тусламж давхардуулахгүйгээр.
- 13.6. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг энэ хуулийн 13.5.1-13.5.5-д заасан өрх, иргэнд нэг удаа, энэ хуулийн 13.5.6-д заасан хүүхдэд сард нэг удаа, энэ хуулийн 13.5.7-д заасан иргэнд улиралд нэг удаа, энэ хуулийн 13.5.8, 13.5.9-д заасан иргэнд жилд нэг удаа тус тус олгоно.
- 13.7. Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр олгоно.
- 13.8. Энэ хуулийн 13.7-д заасан эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх /эцэг/ нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.
- 13.9. Энэ хуулийн 13.2-т заасан иргэнийг асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах бөгөөд уг сургалтын зардлыг нийгмийн үйлчилгээний сангаас санхүүжүүлнэ.
- 13.10. Энэ хуулийн 13.9-д заасан сургалтыг зохион байгуулах журам болон сургалтын хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

28 дугаар зүйл. Нийгмийн ажилтан

- 28.1. Нийгмийн ажилтны мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, ажил, үйлчилгээ явуулах эрх авсан иргэнийг нийгмийн ажилтнаар ажиллуулна.
- 28.2. Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байна.
- 28.3. Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ болон хувийн тэмдэг авсан байна.
- 28.4. Нийгмийн ажилтанд ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ, хувийн тэмдэг олгох, ёс зүйн дүрэм батлан сахиулах ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх орон тооны бус зөвлөл гүйцэтгэнэ.
- 28.5. Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн нь нийгмийн ажлын мэргэжлийн холбоод, нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургууль, холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.
- 28.6. Энэ хуулийн 28.4-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрэм, зөвлөлийн гишүүнд олгох урамшууллын хэмжээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 28.7. Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох зайлшгүй зардал, орон тооны бус зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

28.8. Нийгмийн ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:

- 28.8.1. тухайн сум, хорооны нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 28.8.2. нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрх, иргэнтэй хамтран хийж, хэрэгжүүлэх;
- 28.8.3. тэтгэвэр, тэтгэмж авах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;
- 28.8.4. өрх, иргэдийг хүсэл, зорилго, хэрэгцээгээрээ бүлэг болгон зохион байгуулагдахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- 28.8.5. өрх, иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхтай болоход нь туслах зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
- 28.8.6. орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;
- 28.8.7. нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих;
- 28.8.8. нийгмийн ажилтанд хандсан хувь хүний /хууль зөрчсөн үйлдлийг мэдээлэхээс бусад тохиолдолд/ нууцыг чандлан хадгалах;
- 28.8.9. нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, журам, зааврыг хэрэгжүүлэх;
- 28.8.10. хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн, боловсролын болон бусад нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах.
- 28.8.11. иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл өгөх;
- 28.8.12. өрх, иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд үр дүнтэй хамруулах зорилгоор эрүүл мэнд, боловсролыг дэмжих зэрэг нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай зуучилж өгөх.

/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн/

28.9. Нийгмийн ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:

- 28.9.1. нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйлчилгээнийх нь чанарт хяналт тавих, үнэлгээ хийх;
- 28.9.2. шаардлагатай мэдээ, судалгаа болон холбогдох баримт бичгийг тухайн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;
- 28.9.3. халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн бусад баримттай холбогдсон тайлбар, лавлагаа гаргуулж авах;
- 28.9.4. мэргэжлийн ёс зүй, эрх, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;
- 28.9.5. нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн байгууллага, иргэнийг татан оролцуулах;

/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн/

- 28.9.6. ажлын онцлогоос шалтгаалан тусгай өрөө, эсхүл тусгаарлалт бүхий ажлын байр болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдах.



Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

Төслөөс хүлээж буй үр дүн:

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.